

# Мод мод

$N$  оройтой энгийн граф өгөгдсөн. Өөр лүүгээ орсон ирмэг байхгүй, мөн 2 оройн хооронд хамгийн ихдээ ганц ирмэг байдаг графыг энгийн граф гэнэ. Тэгвэл бүх оройг бүрхсэн хэдэн ширхэг мод үүсгэж болох вэ? (Холбогдсон, циклгүй графыг мод гэнэ)

Оролт:

$N$

$N \times N$   $A$  матриц өгөгдсөн. Хэрэв  $A(i,j)=1$  бол  $i$  болон  $j$ -ээр оройнууд ирмэгээр холбогдсон, үгүй бол  $A(i,j)=0$ . Мөн үргэлж  $A(i,j)=A(j,i)$  байна.

Гаралт:

Бүх оройг бүрхсэн боломжит модын тоо.

Хязгаарлалт:

$1 \leq N \leq 15$

Жишээ:

Оролт:

3

0 1 1

1 0 1

1 1 0

Гаралт:

3